



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/27

Булган сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд усны эх үүсвэрийг бий болгох зорилгоор нуурыг нөхөн сэргээх зураг төсөв (Баяннуур сум) боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: - Т.Баттулга

Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: - С.Алтанзул

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодолого төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

- Б.Баярцэнгэл

Орон нутгийн өмчийн газрын худалдан
авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Иргэний төлөөлөл: - Б.Туяа

Булган сумын иргэн

Нарийн бичгийн дарга: - Б.Бямбасүрэн Орон нутгийн өмчийн газрын худалдан
авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо /Т.Баттулга/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6332011141